

Эхийн найруулгын төрөл



**Өгүүлэгч этгээд санаа бодлоо зөв
оновчтой илэрхийлэхийн тулд хэлний
нэгжүүдийн утга хэлбэрийн хувиргалыг
бүрэн ашиглах ухааныг найруулга зүй
ГЭНЭ.**

Найруулга зүйн ухаанд

Найруулгын
төрөл

Найруулгын
хэв маяг

Найруулгын
өнгө аяс

Найруулгын
зэрэг

YOUR
TITLE

Write your
description here





Уран зохиолын найруулга

Аливаа юмс үзэгдэл, тэдгээрийн зөрчил тэмцэл, хөгжил хувирал, амьдралын ил ба далд учир шалтгаан, хэлхээ холбоо, жам ёсыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн орчилд яруу сайхнаар нээн гаргаж, уншигч сонсогчдын сэтгэл зүрхэнд нөлөөлж, амьдрал тэмцэлд сургамж болгох зорилгоор дүрслэх ба найруулах ур маягийг оновчтой ашиглаж зохиосон яриа бичгийн эхийг уран зохиолын найруулгын эх гэнэ.

Уран зохиолын найруулгын үндсэн шинж:

- Хэлний дүрслэх болон найруулах ур маягийг өргөн ашигладаг
- Уран дүрийг бүтээдэг.
- Үгийн сангийн үүсвэр болон найруулга бүрэлдэхүүний бүхий л нөөцийг

Уран зохиолын найруулгын онцлог

Уран зохиолын найруулгад өгүүлж буй юм үзэгдэл үйл явцыг хүний чихэнд сонсогдож, нүдэнд харагдтал яруу тод өгүүлэхэд өнгө аяс, аялга, өргөлт, үе, авиаг зөв сонгож хэрэглэх нь чухал.

Уран зохиолын эхийг яригч, уншигч, сонсогчдод хүргэж илэрхийлэх ур чадвар чухал үүрэгтэй.

Уран зохиолын найруулгын үгийн онцлог

Уран зохиолын найруулгад үг шилжсэн утгаар хэрэглэгдэх нь түгээмэл. Зохиолын баатрын дүр, үг хэлний онцлогийг гаргах зорилгоор хуучин ба шинэ үг, нутгийн аялгууны үг, ерийн ба этгээд , хүндэтгэлийн ба бүдүүлэг үг хэллэг , бичгийн ба хар ярианы үг, шингэсэн ба харь үг, мэргэжлийн үг хэллэг идэвхтэй , идэвхгүй үг хэллэг зэргийг ашиглана. Мөн уран яруу дүрслэл, чимэг ,тодотгол их чухал учраас тэмдэг нэр, авиа ба дүрс дуурайх үгийг өргөн хэрэглэнэ.

Уран зохионы найруулгын өгүүлбэрийн онцлог

Үргэлжилсэн үгийн зохиолд үйл явдлыг тоочсон, хүүрнэсэн, энгийн ба нийлмэл өгүүлбэр, уянгын буюу яруу найргийн зохиолд хэлэх аялгаар холбогдсон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, жүжгийн зохиолд бүрэн бус болон бүтэц бус өгүүлбэр элбэг.

Өгүүлэгчийн хандлага, үнэлэмж, сэтгэл хөдлөл илэрхийлэх үүрэгтэй баймж нэгжүүд түгээмэл тохиолдоно.

Сонин нийтлэлийн найруулга

Нийтлэлийн хэл найруулгад сонин, нийгэм, улс төрийн сэтгүүл, суртал нэвтрүүлэг, радио телевизийн нэвтрүүлэг, баримтат киноны тайлбар, хурал цуглаан, баяр ёслолын элдэв арга хэмжээнд хэлэх үгийн хэл найруулга зэрэг хамаарна.

Сонин хэвлэлийн үүрэг :

Мэдээлэх

- Баримт хэрэглэгдэхүүн үнэн зөв байх
- Албан ёсны шинжтэй байх
- Тодорхой ,нэгтгэн дүгнэсэн байх

Нөлөөлөх

- Уриалан дуудах
- Яруу сайхны таашаалд нийцэх
- Сурталчлан зарлаж таниулах

Сонин нийтлэлийн хэл найруулга:

- Найруулга нь энгийн , ойлгоход хялбар байна.
- Цөөн үгээр өргөн агуулга гаргана.
- Уран дүрслэл өвөрмөц хэллэгтэй байна.
- Сэтгэлийн өнгө аяс илэрнэ.

Нийтлэлийн найруулга

Нийтлэлийн найруулга нь судалгаа шинжилгээний тунгаан бодсон аястай, нийгмийн чухал асуудлыг хөндсөн, задлан шинжилсэн, нэгтгэн дүгнэсэн, шийдэх арга замыг заасан, үйл явдлын нягт уялдаатай, шинжлэх ухааны нэр томъёог өргөн ашигладаг зэрэг шинж чанараараа шинжлэх ухааны зохиолын найруулгад ойр байдаг.

Нийтийн өмнө хэлж байгаа үгийн найруулга бол үнэн магад, тодорхой баримт, бодит шалтгаан нарийн үндэслэл зэрэг шинжээрээ хар ярианы найруулгаас ялгардаг. Ийм болохоор бас шинжлэх ухааны зохиолын найруулгад ойр талтай. Түүнчлэн нийтлэлийн найруулгын маш чухал шаардлага бол өргөн олон түмэнд зориулагдаж байдаг болохоор хамгийн ойлгомжтой байх ёстой.

Шинжлэх ухааны зохиолын найруулга нь:

- Аливаа тогтолцоо, баримт, судалгааг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, мэдээлэх
- Албан ёсны шинж байдалтай
- Өгүүлэл, илтгэл, сурах бичиг, ганц сэдэвт зохиол цөм хамаардаг.
- Үгсийн сангийн хувьд мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо их хэрэглэдэг.
- Учир шалтгааны нарийн дараалалтай байдаг.
- Нөлөөлөх буюу итгүүлэн батлах тал нь их байдаг.
- Утга санаа тодорхой, нэгтгэн дүгнэсэн байдаг.

Хэлний хэрэгсэл нь шинжлэх ухааны зохиолын мэдээлэх ба нөлөөлөх гэсэн зорилгын хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг.

Энэ найруулгын хамгийн түгээмэл онцлог шинж бол эхийн учир шалтгааны нягт уялдаа юм. Шинжлэх ухааны зохиолд мэдээлэх баталж нотлох нь гол байдаг учраас түүнд уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ашигладаггүй. Харин шинжлэх ухааны сурталчилгааны зохиолд зохих хэмжээгээр ашиглаж болдог.

Ер нь шинжлэх ухааны зохиолын найруулга голдуу бичгийн хэлбэрээр байдаг

Албан бичгийн хэл найруулга

Албан харилцааны үүрэг гүйцэтгэж байгаа баримт бичгийн хэл найруулгыг албан бичгийн хэл найруулга гэнэ. Албан бичгийн найруулга нь тогтсон стандарт, хэв загварын дагуу бичдэг бөгөөд хувь хүний найруулгын онцлог харьцангуй бага туссан байдаг.

Албан бичгийн найруулгын онцлог :

- Тогтсон хэв загвартай
- Утга санаа тодорхой
- Яг таг зааж мэдэгдсэн шинжтэй
- Захирсан хүссэн тушаасан өнгө аястай
- Үгийг шууд утгаар хэрэглэдэг
- Уран яруу хэрэглүүр хэрэглэхгүй
- Сэтгэлийн өнгө аяс илрэхгүй
- Хар ярианы үг, этгээд, бүдүүлэг үг хэллэг, нутгийн аялгууны үг хэрэглэдэггүй
- Өөрийн гэсэн тогтсон үг хэллэгтэй